

# Э-Сонин

26 дахь дугаар



## Мэдээний Тойм



### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД



### ЭДИЙН ЗАСГИЙН СЭТГҮҮЛЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ ЦАН ЦОХИЖ, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН 4,867 ДАХЬ УДААГИЙН АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

### МХБ-Д БҮРТГЭЛТЭЙ ХК-ИУД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТӨВШИНГӨӨ ДЭЭШЛҮҮЛЖ, УЛАМ ТӨГӨЛДӨРЖҮҮЛНЭ



### “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК НЬ “АВЛИГААС АНГИД, САЙН ЗАСАГЛАЛЫН САЙН САНААЧЛАГА” ӨРГӨМЖЛӨЛ ХҮРТЛЭЭ

### 2014 ОНЫ “ШИЛДЭГ ХУВЬЦААТ КОМПАНИ”, “ШИЛДЭГ ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ”-ИЙГ ТОДРУУЛЛАА



### ТӨГСӨЛТИЙН БАЯР

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

### “MSE ALL” ИНДЕКС АЛБАН ЁСООР ТООЦОГДОЖ ЭХЛЭНЭ



### ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- ЗГЖУЦаасны 12 дугаар сарын арилжааны мэдээлэл.
- Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн шийдвэрүүд.
- МХБиржийн удирдлага Хэвлэлийн хүрээлэнгийн дэргэдэх Эдийн засгийн Өөрчлөгч клубийн сэтгүүлчидтэй хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа
- СЗХ, МХБ ТОП-20 индексийг бүрдүүлэгч Хувьцаат компаниудын ТУЗ-ийн дарга нар Сайн засаглалтай хувьцаат компани болохоор хичээж ажиллах “ТУНХАГ БИЧИГ”-г гурвалсан гарын үсэг зурлаа
- “МХБ” ТӨХК “Авлигаас ангид сайн засаглалын сайн санаачлага” өргөмжлөл хүртлээ.
- МХБирж 2014 оны “Шилдэг хувьцаат компани”, “Шилдэг үнэт цаасны компани”-ийг тодрууллаа.
- “MSE ALL” индекс албан ёсоор тооцогдож эхлэхээр боллоо.

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 12-р сарын арилжааны мэдээ

### СУРГАЛТ

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт-ыг 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр явуулахаар төлөвлөж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг утас: 11-313747 /116 дугаараас авна уу.





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний 389 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 23-ны өдрийн 169 дугаар тушаалаар 100.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд арилжаалах шийдвэр гарсан. Энэхүү бондыг долоо хоног болгоны Мягмар гарагт арилжаалсан бөгөөд 12-р сард нийт 23.9 тэрбум төгрөгийн бондын арилжааг 5 өдрийн арилжаагаар арилжсан байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ / ш/	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2014.12.02	ЗГЭБ-Б-12-278	12	26,816	15.96%	2,586,590,912.00
2014.12.09	ЗГЭБ-Б-52-279	52	2,057	16.625%	205,700,000.00
2014.12.16	ЗГЭБ-Б-12-280	12	152,978	15.731	14,763,294,868.00
2014.12.23	ЗГЭБ-Б-28-281	28	4,888	16.436%	449,158,320.00
2014.12.30	ЗГЭБ-Б-12-282	12	61,178	15.653%	5,905,084,094.00
<b>Нийт зарагдсан ЗГҮЦ</b>			<b>127.622</b>		<b>23,909,828,194.00</b>

### “MSE ALL”ИНДЕКС АЛБАН ЁСООР ТООЦОГДОЖ ЭХЛЭНЭ



Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар “Үнэт цаасны индекс тооцох журам”-ыг шинэчлэн баталлаа.

Уг журам хэрэгжсэнээр “MSE ALL” нэгдсэн индексийг албан ёсоор тооцож эхлэхээс гадна сагсан дахь компаниудын зах зээлийн үнэлгээ эрс тэс байгаагаас шалтгаалж нэг үнэт цаасны өсөлт бууралт нь индекст хүчтэй савалгаа үүсгэж зах зээлийн бодит байдлыг гажуудуулж буй явдлыг арилгах зорилгоор нэг үнэт цаасны индекс нөлөөлөх нөлөөллийг 15%-иар хязгаарлах, хаалтын ханш тогтох аргачлалыг өөрчилж тухайн арилжааны өдөр хийгдсэн бүх арилжааны тоо хэмжээний жигнэсэн дундаж ханшаар тооцоолохоор тусгагдсан нь хаалтын ханшийг бодитоор тогтоох ач холбогдолтой юм.

Мөн “ТОП-20” индексийн сагсыг жилд 2 удаа шинэчилж байхаар боллоо.

Санхүүгийн зохицуулах хороо дээрх журмыг батламжилсанаар хэрэгжиж эхэлнэ.





## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД



### НЭР БҮХИЙ ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДЫН АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ ТҮР ХЯЗГААРЛАЛАА

- |                                |                              |
|--------------------------------|------------------------------|
| 1 “Аргай Бэст” ХХК             | 10 “Лайфтайм Инвестмент” ХХК |
| 2 “Асе энд Т Капитал” ХХК      | 11 “Монгол Секюритиес” ХК    |
| 3 “Бага хээр” ХХК              | 12 “Монсек” ХХК              |
| 4 “Батс” ХХК                   | 13 “Новел Инвестмент” ХХК    |
| 5 “Булган Брокер” ХХК          | 14 “Өндөрхаан Инвест” ХХК    |
| 6 “Говийн ноён нуруу” ХХК      | 15 “Превалент” ХХК           |
| 7 “Гүүдсек” ХХК                | 16 “Санар” ХХК               |
| 8 “Дархан Брокер” ХХК          | 17 “Финанс Линк Групп” ХХК   |
| 9 “Дэлгэрхангай Секюритиз” ХХК | 18 “Эм Даблью Ти Эс” ХХК     |

### НЭР БҮХИЙ ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДЫГ ГИШҮҮНЭЭС ХАСЛАА

- |                               |                           |
|-------------------------------|---------------------------|
| 1 “Грандлайн” ҮЦК             | 6 “Сайхан капитал” ҮЦК    |
| 2 “Грийт секьюритис” ҮЦК      | 7 “Соёмбо инвестмент” ҮЦК |
| 3 “Зууны гарц секьюритис” ҮЦК | 8 “Туушин инвест” ҮЦК     |
| 4 “Мөнх-Огторгуй” ҮЦК         | 9 “Юу би би ди” ҮЦК       |
| 5 “Очир-Эрдэнэ инвест” ҮЦК    |                           |

### НЭР БҮХИЙ АРИЛЖААНЫ БАНКНУУДЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 467 дугаар тогтоолоор 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн нэр бүхий банкнуудын “Үнэт цаасны зах зээлд харилцагчийн нэрийн өмнөөс, түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг хүчингүй болголоо. Үүнд:

- |                                |   |
|--------------------------------|---|
| 1 “Улаанбаатар хотын банк” ХХК | 6 “Төрийн банк” ХХК                       |
| 2 “Худалдаа хөгжлийн банк” ХХК | 7 “Капитрон банк” ХХК                     |
| 3 “Чингис хаан банк” ХХК       | 8 “Капитал банк” ХХК                      |
| 4 “Хаан банк” ХХК              | 9 “Хас банк” ХХК                          |
| 5 “Голомт банк” ХХК            | 10 “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК |

### НЭР БҮХИЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО

- |                         |                            |
|-------------------------|----------------------------|
| 1 “Ундарга-Өмнөговь” ХК | 10 “Өв усжуулагч” ХК       |
| 2 “Сав шим” ХК,         | 11 “Мөнхжим” ХК            |
| 3 “Хангал” ХК           | 12 “Баянтоорой” ХК         |
| 4 “Хүнс-Архангай” ХК    | 13 “Оргил Говь-Алтай” ХК   |
| 5 “Дарзам” ХК           | 14 “Эсгий, эсгий гутал” ХК |
| 6 “Ажлын хувцас” ХК     | 15 “Харгиа” ХК             |
| 7 “Чандмань –Уул” ХК    | 16 “Мон-Асар” ХК           |
| 8 “Төв-ус” ХК           | 17 “Дархан Хөвөн” ХК       |
| 9 “Алмаас” ХК           |                            |



## ЭДИЙН ЗАСГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН ТӨЛӨӨЛӨЛ ЦАН ЦОХИЖ, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН 4,867 ДАХЬ УДААГИЙН АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

Үнэт цаасны арилжаа, хөрөнгийн зах зээлийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх зорилгын хүрээнд “Монголын хөрөнгийн бирж”-ээс Хэвлэлийн хүрээлэнгийн дэргэдэх Эдийн засгийн сэтгүүлчдийг 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Хөрөнгийн биржид урьж, өөрийн үйл ажиллагааг танилцуулан, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өгч, хэлэлцүүлэг өрнүүллээ.

Тус арга хэмжээний үер сэтгүүлчдийн Хөрөнгийн зах зээлийн мэдлэгийг дээшлүүлэх, Хөрөнгийн зах зээл дэх хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг эхлүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн бирж Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээг байгууллаа.

Энэ өдөр сэтгүүлчдийг төлөөлж Засгийн газрын мэдээ сонины сэтгүүлч Д.Мөнхчимэг “Цан” цохиж, Монголын хөрөнгийн биржийн 4867 дахь удаагийн арилжааг нээлээ.



## МХБ-Д БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТӨВШИНГӨӨ ДЭЭШЛҮҮЛЖ, УЛАМ ТӨГӨЛДӨРЖҮҮЛНЭ



Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани нь СЗХ-ны 2014 оны 162 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-т тусгагдсан ил тод, нээлттэй, эрх тэгш, хяналттай, хариуцлагатай сайн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн

ажиллаж, нийтэд тайлагнаж байх шаардлагатай байдаг. Хувьцаат компани нь үйл ажиллагаандаа засаглалын зарчмыг хэвшүүлэн өөрийн засаглалын төвшинг үнэлж, түүний хэрэгжилтэд зохицуулах эрх бүхий байгууллагын зүгээс хяналт тавин, заавар зөвлөгөө өгч, зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж байх нь цаашид үнэт цаас гаргагчдын хөрөнгө оруулалт татах чадварыг дээшлүүлэхээс гадна нэр хүнд, цар хүрээгээ тэлэхэд төдийгүй Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжихэд чухал хувь нэмэр болох юм.

СЗХ, Монголын хөрөнгийн бирж, ТОП-20 индексийг бүрдүүлэгч Хувьцаат

компаниудын ТУЗ-ийн дарга нар Сайн засаглалтай хувьцаат компани болохоор хичээж ажиллах “ТУНХАГ БИЧИГ”-т гурвалсан гарын үсэг зурж баталгаажуулах ажиллагааг 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 11 цагт МХБ-д зохион байгууллаа.





## “МХБ” ТӨХК НЬ “АВЛИГААС АНГИД, САЙН ЗАСАГЛАЛЫН САЙН САНААЧЛАГА” ӨРГӨМЖЛӨЛ ХҮРТЛЭЭ

Монголын Хөрөнгийн Бирж нь авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, ажилтны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажлыг амжилттай хэрэгжүүлж ажилласан тул 2014 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газрын “АВЛИГААС АНГИД, САЙН ЗАСАГЛАЛЫН САЙН САНААЧЛАГА” өргөмжлөл хүртлээ.

## 2014 ОНЫ “ШИЛДЭГ ХУВЬЦААТ КОМПАНИ”, “ШИЛДЭГ ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ”-ИЙГ ТОДРУУЛЛАА



Хувьцаа нь хамгийн идэвхтэй арилжигдсан, зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр, тогтмол ногдол ашиг олгодог, мэдээллийн ил тод байдлыг сайн хангаж ажилласан гэх шалгуураар 2014 оны шилдэг хувьцаат компаниар “Говь”ХК болон “АПУ”ХК – иуд сонгогдсон байна.

Мөн Монголын хөрөнгийн бирж нь өөрийн гишүүн үнэт цаасны компаниудыг жил бүр арилжааны идэвхи, үнийн дүн болон харилцагчдад үзүүлж буй үйлчилгээний чанар, хамгийн өндөр амжилт гаргасан үзүүлэлтээр нь шалгаруулдаг ба 2014 оны шилдэг үнэт цаасны компаниар “БиДиСек”ХК болон “ТиДиКапитал”ХХК сонгогдсон байна.



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИНЭ УДИРДЛАГА ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА

2014 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооны дарга З.Нарантуяа болон гишүүд Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагаатай танилцаж, “Цан” цохиж 4884 дахь удаагийн арилжааг нээж, уулзалт ярилцлага хийлээ.

Тус уулзалтын үеэр Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулга хийж, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлага, ойрын үед хэрэгжүүлэх ажлуудын талаар дэлгэрэнгүй ярилцаж, санал солилцлоо.







**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ  
ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ**

ТӨГСӨЛТИЙН БАЯР



“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2014 оны 12 дүгээр сарын 15-наас 23-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Энэ удаагийн сургалтанд амжилттай суралцсан 15 суралцагч сертификат гардан авлаа.

Сургалтанд цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2015 оны 1 дүгээр сарын сүүлээр 26-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

*Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье*



## ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2014 оны 12 дугаар сар


### Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	7,875,808
Нийт үнийн дүн	28,013,649,069
Хэлцлийн тоо	751
Арилжигдсан үнэт цаасны тоо	56
Зах зээлийн үнэлгээ	1,442,655,414,438

### ТОП-20 индекс

Хаалт	14,854.24
Өмнөх сарын хаалт	14,919.19
Өөрчлөлт /нэгж/	-64.95
Өөрчлөлт /%/	-0.44
52 долоо хоног дээд	17,160.49
дээд	13,422.43

### ТОП 20 ИНДЕКС



### Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:					Үнийн дүнгээр:				
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн
1	ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	6,300,750	630,074,950	1	MBG	МОН-ИТ БУЛИГА	137,996	994,269,900
2	APP	АЗИАПАСИФИК ПРОП	350,520	865,784,400	2	APP	АЗИАПАСИФИК	350,520	865,784,400
3	MBG	МОН-ИТ БУЛИГААР	137,996	994,269,900	3	ETR	Э-ТРАНС ЛОЖИС	6,300,750	630,074,950
4	SCR	СОР	124,369	201,011,135	4	SCR	СОР	124,369	201,011,135
5	HGN	ХӨХ ГАН	37,715	3,829,072	5	TTL	ТАВАН ТӨЛГӨЙ	17,509	75,194,724

### Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	BHR	БИНСЭ ХК	600.00	720.00	120	20.00
2	HRM	ГЕРМЕС ЦЭНТР	150.13	170.00	20	13.24
3	BHL	БӨӨНИЙ ХУДАЛДАА	700.00	784.50	85	12.07
4	HBO	ХАЙ БИ ОЙЛ	550.00	594.00	44	8.00
5	EER	АРИГ ГАЛ	2,600.00	2,808.00	208	8.00

### Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	HHC	БИШРЭЛТ ИНДАСТРИ	4,500.00	2,470.00	-2,030	-45.11
2	DLG	МОНГОЛ МАХ ЭКСПО	5,500.00	3,780.00	-1,720	-31.27
3	SCR	СОР	2,185.00	1,800.00	-385	-17.62
4	BAN	БАГАНУУР	3,500.00	2,899.00	-601	-17.17
5	MBH	МОНГОЛ ШИЛТГЭЭН	690.00	590.00	-100	-14.49

### Засгийн газрын үнэт цаас:

№	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Хүүгийн хэмжээ % /жил/	Нэрлэсэн үнэ	Хямдруулсан үнэ
1	ЗГЭБ-Б-12-278	26,816	2,586,590,912	15.96	100,000	96,457
2	ЗГЭБ-Б-52-279	2,057	205,700,000	16.625	100,000	100,000
3	ЗГЭБ-Б-12-280	152,978	14,763,294,868	15.731	100,000	96,506
4	ЗГЭБ-Б-28-281	4,888	449,158,320	16.436	100,000	91,890
5	ЗГЭБ-Б-12-282	61,178	5,905,084,094	15.653	100,000	96,523

### Анхдагч зах зээлийн арилжаа:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Нэгж үнэ
1	BDS	БИДИСЕК	520,722	1,117,469,412	2,146

